



**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

15170 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3,
Утас: 7600 3333, 31 06 12, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2019. 07. 10 № 03/2472

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАРТ

Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 52 дугаар захирамжаар байгуулагдсан Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг (2020-2045) боловсруулах ажлын хэсэгт мэргэжил, аргазүйн дэмжлэг үзүүлэх, салбарын чиглэлээр бодлогын санал боловсруулах Ажлын хэсгийг Сайдын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 99 дүгээр тушаалаар, бодлогын санал боловсруулах дэд ажлын хэсгүүдийг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/88 дугаар тушаалаар тус тус байгуулан ажиллаж, барилга, хот байгуулалтын салбарын 2020-2045 оны бодлогын саналыг 10 хавсралтаар гарган хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

08 02685



БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 07 дугаар сарын 02

№ 06

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН нь:

Монгол Улсыг 2020-2045 онд хөгжүүлэх урт хугацааны бодлогын баримт бичгийн талаар санал боловсруулах ажлын явцын талаарх танилцуулга.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Дэд ажлын хэсгүүд чиглэл чиглэлээрээ хийсэн ажлуудаа нэгтгэн эцэслэж, 7 дугаар сарын 9-ний өдөр Үндэсний хөгжлийн газарт албан бичгээр хүргүүлэхээр тогтов.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



03 00045

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ №06 -ээс

2019.07.02

Барилга, хот байгуулалтын Сайдын зөвлөлийн хуралдаан 2019 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 8.30 цагт Барилга хот байгуулалтын яамны хурлын танхимд хуралдав.

Хуралдаанд Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Л.Батжаргал, ТЗУГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярсайхан, Сайдын орон тооны бус зөвлөх Б.Баасан, ГХГЗЗГ-ын дарга Ц.Ганхүү, БХТ-ын захирал Ц.Амарсанаа, Монголын Барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга Б.Батцогт, ХСУХАТАҮЗЗ-ийн дарга Ж.Батсуурь, Монголын барилгачдын нэгдсэн холбоо ТББ-ын ерөнхийлөгч М.Батбаатар, Барилгын хөгжлийн үндэсний нэгдсэн төвийн тэргүүн Г.Мягмар, Барилгын материалын үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч М.Түмэнжаргал, Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ-ын ерөнхийлөгч Б.Чулуундолгор нар оролцов.

Хуралд нийт ирвэл зохих 21 гишүүнээс ирсэн 13, ирээгүй 8.
Хурлын ирц 61 % .

Сайдын зөвлөлийн хуралдааныг Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан даргалав.

Х.Баделхан: Эрхэм сайдын зөвлөлийн гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргье. Өнөөдрийн хурлаар 3 асуудал хэлэлцэж 1 танилцуулга сонсоно. Хэлэлцэх асуудлаа батлах уу? За санал нэгтэй баталлаа.

ХЭЛЭЛЦСЭН НЬ 4: Монгол Улсыг 2020-2045 онд хөгжүүлэх урт хугацааны бодлогын баримт бичгийн талаар санал боловсруулах ажлын явцын талаарх танилцуулга.

Танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч Л.Шагдаррагчаа танилцуулав.
/Танилцуулгыг хавсаргав./

Х.Баделхан: Та бүхэн танилцуулгыг сонслоо. Санал хэлж, асуултандаа орьё.

Б.Баасан: Надад нэг асуулт байна. Салбар салбар нэг бодлого гаргаж, тэрийг нэгтгэх нь гэж ойлгож байна. Миний бодлоор улс 2020-2045 онуудад ингэж хөгжинө гээд аргументаа тавиад, тэр аргументад тааруулж салбар салбараар бууж ирвэл их уялдаатай болох байжээ. Ерөөсөө салбар болгон өөр өөрийн бодлогыг шууд тавьчихвал, яг нэгдээд базаад ирэхээр уялдаа хэр байх бол? Эхнээсээ төр бодлогоо дээрээсээ гаргаж, түүнд нь манай салбарууд өөрийн бодлогоо тааруулж гаргаж явбал яг жинхэнэ төлөвлөлт гарна. Тэгэхгүй бид нар тонгоруу яваад байна.

Л.Шагдаррагчаа: Яг зөв асуулт тавьж байна. Энэ бэрхшээл бидэнд яг боловсруулалтын шатанд тулгарч байгаа. Өнөөдөр улс энийг тэдэд багтаагаарай гэсэн бодлогын өгөгдлүүд, нэг ч тоо ерөөс байхгүй. Би СЯ-аас эдийн засгийн макро товшний тосөөллийн судалгаа хийж байгаа хүмүүсээс өсөлтийн тарифын илэлцүүр, хувь хэмжээг олж авсан. Энэ нь хүртэл батлагдаагүй. Надад хувийн журмаар салбарыхаа бодлогын баримтад ашиглаарай гэж өгсөн. Улсын хөгжлийн цогц бодлогод өсөлтийн төсөөллийн тоог гаргасныг салбар руу хөрвүүлээд хийгээд байж байна. “Монгол Улсын урт хугацааны бодлого 2020-2045” баримт бичиг бүх яам тамгын газар, аймагт боловсруулалт яг одоо хийгдэж байна. Засгийн газрын нэгдсэн цахим платформ дээр маягтаар нэгтгэж аваад улсын тоон өгөгдлийг Үндэсний хөгжлийн газар гаргаж авах гэж байна. 2019-2023 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр гарсан. Энэ нь ажлын өсөлтийн хэмжээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн хэмжээг гаргаад сайдуудад хуваасан. Сангийн яам өсөлтийн коэффициентээ гаргахаар сууж байна. Бүх салбарын тооцоогоо гаргаад ирэхээр нэгдсэн цахим маягт тооцоолол хийгээд ирэхээр салбар дундын зохицуулалтаа яахав, үндэсний хөгжлийн үзэл баримтлалаа яахав, нутагшилт суурьшлаа яахав, газар зохион байгуулалтаа яахав гээд салбар дундын бодлого, улсын хэмжээний бодлогын зохицуулалтыг уялдуулдаг программ гарна.

Г.Мягмар: Миний бодлоор энэ боловсруулж буй баримт бичгийг “Барилга, хот байгуулалтын хөгжлийн бодлого 2020-2045”, дараагийх нь 2020-2025 онд хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө гэсэн нэртэй баймаар байна гээд нэрнээсээ эхлээд ярих юм байна.

Л.Шагдаррагчаа: Бидний хувьд бүх юмаа хийсэн. Танай хот байгуулалт, нутагшил суурьшлын ажлын хэсэг ажлаа хийгээгүйгээс болоод бид юмаа нэгтгэж чадахгүй байна. Газрын дарга Гүнболд нь байхгүй гээд ажил зогсож болохгүй, газрынх нь хүмүүс байж л байна.

С.Магнайсүрэн: Өчигдөр бид суугаад юмаа яриад энэ талаар сайдад бас танилцуулсан. Сайд сайдын зөвлөлийн гишүүдээсээ санал авья гэсэн. Хүрээ, суурь, ерөнхий хана бол боссон. Одоо бид юу хийх үү гэвэл үндсэн зорилтын хүрээнд үйл

ажиллагааны чиглэлүүдээ тодорхой байлгах шаардлагатай байна. Зарим нэр томъёог эргэж харах, нэг форматанд оруулахыг би Баярбат, Гантулга, Энхтүвшин, Гантөмөр нарт даалгаж байна. Системчлэх талд нь анхаарч туслаад, чиглэл чиглэлээрээ нийлээд суугаад ерөнхий гол юмаа зангидаад 7 дугаар сарын 8-нд эцэслэн дүгнэе.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Дэд ажлын хэсгүүд чиглэл чиглэлээрээ хийсэн ажлуудаа нэгтгэн эцэслэж, 7 дугаар сарын 9-нд Үндэсний хөгжлийн газарт албан тоотоор хүргүүлэхээр тогтов.

Өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурал өндөрлөж байна. Та бүхэн сайхан наадаарай.

Сайдын зөвлөлийн хурал 12.00 цагт өндөрлөв.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН БАГЦ ТОВЬЁОГ

№	Бодлогын баримт бичгийн холбогдох зорилго, зорилт	Байгуулагч а хувь хүн	Санал гаргасан				Тусгасан эсэх (Тайлбар, үндэслэл)
			Нэмэлт оруулах	Хасгах	Өөрчлөх	Найруулах	
1.	<p>1. Оюун-Эрдэнэ сайд яамтай уулзалт хийхдээ хот байгуулалттай холбоотой асуудалд ач холбогдол өгч нэлээн санал хэлсэн. Хаяа дагуул хот, Майдар, Аэро сити, Оюутны хотхон гм энэ асуудлыг анхаарах,</p> <p>2. Боловсон хүчний сургалттай холбоотой асуудлыг яаж авч үзэх вэ? Өндөр хөгжилтэй оронд ЕБС төгсөгчдийн 60%-ийг мэргэжилтэй ажилтан бэлддэг. Дээд сургууль төгссөнөөсөө ч илүү ажлын байраар хангагддаг. Манайд МСҮТ-ээр 100000 тэтгэлэг өгөөд байхад ч мэргэжилтэй ажилчдын хэрэгцээ шаардлага хангагдахгүй байна. Боловсон хүчний асуудлыг заавал оруулах</p> <p>3. Дарханы цэвэрлэх байгууламж, аймаг, орон нутгаар задарсан цэвэрлэх байгууламжуудыг тусд нь базаж томъёолох</p> <p>4. Газар зохион байгуулалтын семинар хийж гэсэн арга хэмжээг хасах</p>	Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн	1	2		3	<p>1. Төслийн жагсаалтад /3-р хавсралт/ оруулсан.</p> <p>2. Мэргэжилтэй ажилчдын тоо хэдээр өсөх, ажлын байр хэд бий болох талаар хавсралтаар тооцоолол хийгдсэн. Энэ нь ХНХЯ-ны эрхлэх хүрээний асуудал ч гэсэн барилгын салбарт чухал тул 2020-2025 оны бодлогод оруулсан.</p> <p>3. Цэвэрлэх байгууламжуудын асуудлыг нэгтгэн томъёолж, ерөнхий оруулсан.</p> <p>4. Хассан</p>
2.	<p>1. Орон сууцны ипотекийн зээлийг шийдвэрлэхэд үнэт цаасны 2 дахь зах зээлийг оруулах</p> <p>2. Мэргэжилтэй ажилчдын бүртгэл, мэдээллийг гаргах асуудал чухал байна. Хөдөлмөр хамгааллын хяналтын картаар дамжуулан хянах механизмыг бий болгох</p> <p>3. Бригадын системийг устгах асуудал тусах шаардлагатай.</p>	Барилгачдын нэгдсэн холбоо Б.Батбаатар	1	2			<p>1. Арга хэмжээ нэмсэн. Сангийн яам, СЗХорооны хариуцах асуудал боловч энэ барилгын салбарт чухал асуудал</p> <p>2. Ажиллах хүчний асуудлыг 5 дугаар хавсралтад оруулсан.</p> <p>3. Энэ талаар тусгах шаардлагагүй.</p>
3.	<p>1. Бүх сумдуудад төлөвлөлт хийж програмчлагдана. Жилийн төлөвлөгөөнд туссан ажлууд л хийгдэх</p>	ГХГЗЗГ-ын дарга Ц.Ганхүү	1				<p>1. Төлөвлөгөөнд тусгасан.</p> <p>2. Зассан</p>

	<p>тул төлөвлөлтөд суурилан бүтээн байгуулалт хийгдэхээр оруулах</p> <p>2. Тааламжтай байдлын биш тохиромжтой байдлын үнэлгээ гэх</p> <p>3. Төвлөрсөн шугам сүлжээнээс хамааралгүй технологийн шийдлийг оруулах</p> <p>4. Орон сууцны чиглэлээр 2-догч зах зээлийн асуудлыг оруулахаар гадаадын иргэд байр эзэмши нь ихсэнэ гээд хэрэгжээгүй, уул уурхайн баялгийн сангаас ХО хийх</p>			2			<p>3 2020-2045 бодлогод оруулсан.</p> <p>4. 2020-2045 бодлогод оруулсан.</p>
4.	1. Хот байгуулалт гэхээр дэд бүтэц болоод бүх асуудал орно, хот төлөвлөлт гэж томъёолох хэрэгтэй.	ШУТИС-ийн БАС-ын багш С.Амгалан			1		Хот байгуулалтын тухай хуулийн дагуу хот төлөвлөлтийн хүрээнд бичсэн.
5.	<p>1. Хотын үйл ажиллагааг смарт буюу ухаалаг болгох асуудлыг Сүүл хот төлөвлөсөн байсан</p> <p>2. Хог хаягдал бол хог хаягдал гэж яригдахаа болсон түүхий эд гэж яригдаж байгаа гм орчин үеийн шаардлагууд нэлээн гарч ирж байна.</p>	ШУТИС-ийн ХБОС-ын багш С.Чулуунхуяг	1	2			1, 2-ыг төлөвлөгөөнд оруулсан.
6.	1. Барилгын материал үйлдвэрлэлийн салбар нь аж үйлдвэрийн салбар тул зорилго, зорилтыг барилгын бодлогоос тусд нь тодорхойлох шаардлагатай	БМҮХ О.Лхагвадорж					Тусд нь зорилт болгож оруулсан.
7.	<p>1. Үзэл баримтлалыг тодорхойлохдоо дотогшоо бус гадагшаа судалгаа хийж байж, систем тогтолцоог тодорхой болгох шаардлагатай.</p> <p>2. Хүний нөөцийг чадавхижуулах нь асуудлыг тусд нь зорилт, арга хэмжээ гаргах</p>	ЗТЗХ – Д.Гантулга	1, 2				<p>1. SWOT & PESTEL шинжилгээ, Эрсдлийн шинжилгээ хийж нэгдсэн дүгнэлт өгсөн. Гадаад дотод орчны шинжилгээ нөлөөллийг тооцож есөлтийн тооцооллын үндэслэлийг хүчин зүйлсийн үнэлгээгээр гаргасан. Нөлөөлөл, үр дүнгийн шинжилгээ хийсэн.</p> <p>2. Тусд нь зорилт, арга хэмжээ болгон оруулсан.</p>
8.	1. Барилгын салбарын үйлдвэрийн ослыг тэглэх асуудлаар ХАБЭА-н зардлыг норм, дүрэмд заасны дагуу зарцуулах талаар тусгах	МБҮЭХ Б.Батцогт	2				<p>1. Захиалагчтай байгуулсан гэрээгээр зохицуулна.</p> <p>2. Төрөөс барилгын салбарын талаар</p>

	2. ХАБЭА-н сургалтыг ямар менежментээр явуулах, хариуцлагын тогтолцоог тусгах						баримтлах бодлогод туссан.
9	Бодлогын баримт бичиг хэд хэдэн ЗГ үе дамжсан байдлаар хэрэгжүүлнэ. Удахгүй сонгууль болохтой холбогдуулаад үүнийг анхаарах. 1. Үг хэллэг хуучинсаг байна, 2. Шинжлэх ухаан, технологи, боловсон хүчин, хот байгуулалтын талаар бага арга хэмжээ тусгагдсан байгааг анхаарна уу.	Барилга архитектур корпорацийн ерөнхий захирал <u>Д.Хайсамбуу</u>				2	1. Бодлогын баримт бичиг, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний бичиглэлийг дахин хянасан. 2. Бодлого, төлөвлөгөөнд тусгагдсан.